

МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч,
ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны
зардал гаргуулах журам батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.5, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1. “Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал гаргуулах тухай журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Сонгуулийн штабын ажилтны бүртгэл”-ийн маягтыг 2 дугаар хавсралтаар, “Нэр дэвшигчийн менежерийн бүртгэл”-ийн маягтыг 3 дугаар хавсралтаар, “Нэр дэвшигчийн шадар туслагчийн бүртгэл”-ийн маягтыг 4 дүгээр хавсралтаар, “Нэр дэвшигчийн ухуулагчийн бүртгэл”-ийн маягтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг сонгуулийн хороодын дарга, ахлах зохион байгуулагч нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн
08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**СОНГУУЛИЙН ШТАБЫН АЖИЛТАН,
МЕНЕЖЕР, ШАДАР ТУСЛАГЧ, УХУУЛАГЧИЙН
ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДАЛ ГАРГУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчаар бүртгүүлэх, үйл ажиллагааны өдөр тутмын зардлыг гаргуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Нам, эвсэл, хамтарсан намын сонгуулийн штабын бүрэлдэхүүнд нам, эвслийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалтнаас гадна түүний ажилтан, нэр дэвшигчийн сонгуулийн штабын бүрэлдэхүүнд нэр дэвшигчээс гадна түүний менежер, шадар туслагч, ухуулагч тус тус хамаарна.

1.3. Нэр дэвшигч нь Сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т заасан тооны менежер, шадар туслагч, ухуулагчтай байна.

1.4. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчаар 18 насанд хүрсэн, энэ журамд заасны дагуу бүртгүүлж, үнэмлэх авсан иргэнийг ажиллуулна.

1.5. Сонгуулийн штаб, түүний ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглох бөгөөд сонгуулийн сурталчилгаанд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч аливаа хэлбэрээр оролцохыг хориглоно.

Хоёр. Нам, эвсэл, хамтарсан намын сонгуулийн штабын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, Ухуулагчаар бүртгүүлэх, үнэмлэх олгох

2.1. Нам, эвсэл, хамтарсан намууд нь сонгуулийн штабын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар бүртгүүлж үнэмлэх авах тухай хүсэлтээ Сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу холбогдох сонгуулийн хороонд бичгээр гаргана.

2.2. Нам, эвсэл, хамтарсан нам, нэр дэвшигч нь энэ журмын 2.1-д заасан хүсэлтийн хамт дор дурьдсан баримт бичгийг ирүүлнэ:

2.2.1. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчаар ажиллуулах тухай баримт бичгийн хуулбар;

2.2.2. Холбогдох маягтын дагуу бөглөсөн мэдээлэл.

2.3. Энэ журмын 2.1-д заасны дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан сонгуулийн хороо 48 цагийн дотор нягтлан шалгаж, энэ журмын 1.4-т заасан шаардлага хангасан этгээдийг бүртгэж үнэмлэх олгоно.

Гурав. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал

3.1. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн зөвхөн өдөр тутмын үйл ажиллагааны дор дурдсан зардлыг Сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан сонгуулийн зардлаас гаргуулна.

3.1.1. Холбооны зардал;

3.1.2. Хоолны зардал;

3.1.3. Унаа эсхүл шатахууны зардал.

3.2. Энэ журмын 3.1-д заасан зардал нь Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.4-т заасан холбогдох зардалд хамаарна.

3.3. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч нь энэ журмын 3.1.1-3.1.3-т заасан зардлыг зориулалтын дагуу зарцуулах ба зардал авсан баримтанд гарын үсэг зурж, зардлын тайланг сонгуулийн штабтаа гаргах өгөх үүрэгтэй.

***Дөрөв. Сонгуулийн штабын ажилтан, менежер,
шадар туслагч, ухуулагчийн эрх, үүрэг***

4.1. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч нь Сонгуулийн тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.2. Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч нь Сонгуулийн тухай хууль болон энэ журамд нийцсэн үйлдэл, үйл ажиллагааг явуулна.

Тав. Хариуцлага

5.1. Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

(Энэ журамд 2016 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 174 дүгээр тогтоол, 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон.)

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн
08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Сонгуулийн хэлбэр:.....
Сонгуулийн төрөл:.....
Нам, эвсэл, хамтарсан намын нэр:.....

НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ШТАБЫН АЖИЛТНЫ БҮРТГЭЛ

№	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр	Ажил, албан тушаал	Намын харъяалал	Сонгуулийн штабт эрхлэх ажил	Харилцах хаяг, утас	Бүртгүүлсэн огноо	Үнэмлэхийн дугаар
А	Б	В	Г	Д	Е	Ж	З

Тамга

**Сонгуулийн Ерөнхий Хорооны
нарийн бичгийн дарга**

/...../

..... он сар өдөр

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн
08 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

Сонгуулийн хэлбэр:.....
Сонгуулийн төрөл:.....
Нэр дэвшүүлсэн нам,
эвсэл, хамтарсан намын нэр:.....
Нэр дэвшигчийн нэр:.....

НЭР ДЭВШИГЧИЙН МЕНЕЖЕРИЙН БҮРТГЭЛ

№	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр	Ажил, албан тушаал	Нэр дэвшигчийн нэр	Харилцах хаяг, утас	Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо	Үнэмлэхийн дугаар
А	Б	В	Г	Д	Е	Ж

Тэмдэг
сонгуулийн хорооны
дарга

/...../

..... он сар өдөр

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн
08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

Сонгуулийн хэлбэр:.....
Сонгуулийн төрөл:.....
Нэр дэвшүүлсэн нам,
эвсэл, хамтарсан намын нэр:.....
Нэр дэвшигчийн нэр:.....

НЭР ДЭВШИГЧИЙН ШАДАР ТУСЛАГЧИЙН БҮРТГЭЛ

№	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр	Ажил, албан тушаал	Нэр дэвшигчийн нэр	Харилцах хаяг, утас	Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо	Үнэмлэхийн дугаар
А	Б	В	Г	Д	Е	Ж

Тэмдэг
сонгуулийн хорооны
дарга

/...../

..... он сар өдөр

Сонгуулийн Ерөнхий Хорооны
2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн
08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

Сонгуулийн хэлбэр:.....
Сонгуулийн төрөл:.....
Нэр дэвшүүлсэн нам,
эвсэл, хамтарсан намын нэр:.....
Нэр дэвшигчийн нэр:.....

НЭР ДЭВШИГЧИЙН УХУУЛАГЧИЙН БҮРТГЭЛ

№	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр	Ажил, албан тушаал	Нэр дэвшигчийн нэр	Харилцах хаяг, утас	Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо	Үнэмлэхийн дугаар
А	Б	В	Г	Д	Е	Ж

Тэмдэг
**сонгуулийн хорооны
дарга**

/...../

..... он сар өдөр

